



МОНГОЛЫН ОЛОН УЛСЫН БА ҮНДЭСНИЙ  
СПОРТЫН АРБИТР



## ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ДҮРЭМ

2023 оны 10 дугаар сарын 20-ны  
өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлнэ.

Удирдах зөвлөлийн  
2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн 23/17 тоот  
тогтоолын хавсралтаар батлав.

## ДАВЖ ЗААЛДАХ КОМИССЫН ДҮРЭМ

### НЭГ. ДАВЖ ЗААЛДАХ КОМИСС, ТҮҮНИЙ ЧИГ ҮҮРЭГ

- 1.1. Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитр (цаашид “Спортын арбитр” гэх)-ын дэргэдэх допингийн Давж заалдах комисс (цаашид “Давж заалдах комисс” гэх) нь Дэлхийн Допингийн эсрэг дүрэм (ДДЭД)-д нэгдсэн Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 376 дугаар тогтоолоор батлагдсан “Допингийн эсрэг үндэсний дүрэм” (цаашид “ДЭҮД” гэх)-ийн 13 дугаар зүйлийн 13.8-т “Дэлхийн допингийн эсрэг дүрмийн 13.2.1 дэх заалтыг хэрэглэх боломжгүй нөхцөл байдал үүссэн үед шийдвэрийг Монголын Олон улсын ба Үндэсний Спортын арбитрын давж заалдах комисст өргөдөл гаргана. Давж заалдах үйл ажиллагааг “Үр дүнгийн удирдлагын олон улсын стандарт”-ын дагуу хийнэ” гэж заасны дагуу байгуулагдсан болно.
- 1.2. Давж заалдах комисс нь допингийн эсрэг дүрмийг зөрчсөнтэй холбоотой хэрэг, маргааныг бие даан, хараат бусаар анхан болон давж заалдах журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа (үр дүнгийн удирдлагын ажиллагаа)-г явуулж, шийдвэр гаргах зорилго бүхий Спортын арбитрын дэргэдэх байнгын үйл ажиллагаатай Комисс мөн.
- 1.3. Үр дүнгийн удирдлагын ажиллагаа (цаашид “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа” гэх) нь эрх бүхий байгууллага, тамирчин болон бусад этгээд допингийн эсрэг дүрмийг зөрчсөн эсэх, зөрчсөн бол холбогдох шийтгэлийг оногдуулахаар явуулж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хэлнэ.
- 1.4. Давж заалдах комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг нь арбитрын ажиллагаа гэж үзэхгүй, түүнд хамаарахгүй болно.
- 1.5. Комисс нь орон тооны бус дарга, зургаагаас доошгүй гишүүнээс бүрдэж, гурван гишүүний бүрэлдэхүүн (цаашид “Бүрэлдэхүүн” гэх)-ээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулна.
- 1.6. Комисс нь Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотод байрлана.
- 1.7. Комисс нь өөрийн эмблем, нэр бүхий тамга тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.
- 1.8. Комисс нь өөрөө болон талуудын хүсэлтээр түргэвчилсэн ажиллагааг явуулахад бүх талын туслалцаа, дэмжлэг үзүүлнэ.
- 1.9. Комиссын үндсэн чиг үүрэг:
  - 1.9.1. Комиссын үйл ажиллагааг Олон улсын стандартад нийцүүлэн хөгжүүлэх;
  - 1.9.2. Комиссын хэлэлцээр, харьяалал бүхий маргааныг шийдвэрлэх;
  - 1.9.3. Комисс нь Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрмүүдэд заасан допингтой холбоотой маргааныг шийдвэрлэх;
  - 1.9.4. Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг “Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандарт”-д нийцүүлэн явуулах;
  - 1.9.5. Олон улсын болон тивийн, бүсийн, улсын болон төрийн, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.
  - 1.9.6. Спортын холбоо, клуб, тамирчин, багш, дасгалжуулагч болон хөрөнгө оруулагч, хуулийн этгээд, олон нийтэд сурталчилан таниулах, энэ зорилгоор танилцуулга, гарын авлага, ном гаргах, соён гэгээрүүлэх ажил явуулах.
  - 1.9.7. Комиссын үйл ажиллагааны талаар судалгааны ажил хийх, сургалт зохион байгуулах, мэргэшүүлэх;
  - 1.9.8. Олон улсын холбогдох байгууллага, төвүүдтэй ажил хэрэгч холбоо тогтоон, хамтын ажиллагаа, харилцааг хөгжүүлэх;
  - 1.9.9. Бүрэлдэхүүний ажиллагааны нууцыг хадаглах;
  - 1.9.10. Комиссын болон Бүрэлдэхүүн бие даасан, хараат бус, шударгаар түргэн шуурхай явуулах зэрэг болно.

- 1.9.11. Олон улсын гэрээ, конвенц, хууль тогтоомжинд заасан бүрэн эрх
- 1.9.12. Холбооны болон Спортын арбитраас баталсан чиг үүрэг
- 1.9.13. Бусад

## **ХОЁР. КОМИССЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 2.1. Холбооны Удирдах зөвлөл Комиссын дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
  - 2.1.1. Комиссыг байгуулах, дүрмийг батлах;
  - 2.1.2. Комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрмийг батлах;
  - 2.1.3. Комиссын зардлын журмыг батлах;
  - 2.1.4. Комиссын гишүүдийн нэрсийн жагсаалтыг батлах, өөрчлөлт оруулах;
  - 2.1.5. Холбогдох дүрэм, журмыг батлах;
  - 2.1.6. Хууль болон дүрэм, журамд заасан бүрэн эрх;
- 2.2. Комисс нь дараах бүтэц зохион байгуулалттай байна:
  - 2.2.1. Дарга
  - 2.2.2. Гишүүд
  - 2.2.3. Ажлын алба
  - 2.2.4. Нарийн бичгийн дарга

## **ГУРАВ. КОМИССЫН ДАРГА, ТҮҮНИЙ БҮРЭН ЭРХ**

- 3.1. Комиссын дарга нь Спортын арбитрын Ерөнхийлөгч байна.
- 3.2. Комиссын дарга нь заасан бүрэн эрхийн хүрээнд шийдвэр гаргах бөгөөд шийдвэр нь тушаал, шийдвэр хэлбэртэй байна.
- 3.3. Комиссын дарга нь дараах эрх үүрэгтэй.
  - 3.3.1. Комиссыг гадаад, дотоодод аливаа асуудлаар итгэмжлэлгүй төлөөлөх;
  - 3.3.2. Комиссыг төлөөлөн санамж, гэрээ, хэлцэл байгуулах;
  - 3.3.3. Комиссын гишүүдийг томилох, чөлөөлөх, хугацаанаас нь өмнө бүрэн эрхийг дуусгавар болгох;
  - 3.3.4. Комиссын хэрэг үүсгэх;
  - 3.3.5. Бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх;
  - 3.3.6. Комиссын үйл ажиллагаа хөгжүүлэх зорилгоор бодлого боловсруулах, үйл ажиллагааг сурталчлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;
  - 3.3.7. Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүний хавсаргалууд, Допингийн эсрэг үндэсний дүрэм, Үр дүнгийн удирдлагын Олон улсын стандарт, Комиссын хэрэг хянан шийдвэрлэх дүрэм болон энэхүү дүрэмд заасан бүрэн эрх хэмжээний хүрээнд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох, шийдвэр гаргах;
  - 3.3.8. Комиссыг төлөөлөн бусдаас хандив, тусламж, бэлэг хүлээн авах, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх;
  - 3.3.9. хууль болон дүрэм, журамд заасан бусад бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

## **ДӨРӨВ. КОМИССЫН ГИШҮҮН**

- 4.1. Комиссын гишүүн нь Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасны дагуу хууль (хуульчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн, нарийн мэргэшсэн хуульч), анагаах ухаан (нарийн мэргэшсэн эмч, эрдэмтэн, багш, судлаач), спорт (спортын мэргэжил, цол зэрэг дэвтэй тамирчин, ажлын дадлага

- туршлагатай багш, дасгалжуулагч, шүүгч, эрдэмтэн, судлаач)-ын салбарт ажиллаж байсан ажлын өндөр дадлага туршлагатай, эрүүгийн ял шийтгэл эдэлж байгаагүй 35-аас дээш настай байх шалгуурыг хангасан Монгол Улсын иргэд нэр дэвшиж 3 жилийн хугацаагаар томилогдоно.
- 4.2. Энэхүү дүрмийн 3.3.3 дахь заалтыг үндэслэж Холбооны Удирдах зөвлөлөөс нэрсийн жагсаалтыг баталж, гишүүдийн нэрсийг эрэмбэлэхдээ Монгол цагаан толгойн дэс дарааллыг баримтална.
- 4.3. Комиссын гишүүд “Комиссын гишүүн би Олон улсын болон Үндэсний биеийн тамир, спортын байгууллага, тамирчдын эрх, эрх чөлөө, шударга ёс, хуулийг дээдлэн хамгаалж допингийн хэрэг, маргааныг хараат бусаар, зөвхөн Монгол Улсын Үндсэн хууль, Спортод сэргээш хэрэглэхийн эсрэг Олон улсын конвенц, Дэлхийн допингийн эсрэг дүрэм, түүний хавсралтууд, Допингийн эсрэг үндэсний дүрэмд нийцүүлэн шийдвэрлэж, ёс зүйг чанд сахиж явахаа батлан тангарагъя. Миний бие өргөсөн тангаргаасаа няцвал ёс зүйн хатуу цээрлэлийг хүлээнэ” гэсэн тангаргийг Спортын арбитрын туганд өргөж, гарын үсэг зурж баталгаажуулна.
- 4.4. Комиссын гишүүд дараах эрхийг эдэлнэ.
- 4.4.1. Бүрэлдэхүүнд томилогдох, татгалзах;
- 4.4.2. хэргийн материалтай танилцах, энэ талаар мэдээлэл авах;
- 4.4.3. Комиссын ажиллагааг шуурхай явуулах талаар санал гаргах, нарийн бичгийн даргад үүрэг өгөх;
- 4.4.4. Гишүүний урамшуулал буюу хөлс авах;
- 4.5. Комиссын гишүүд дараах үүргийг хүлээнэ.
- 4.5.1. зохион байгуулж буй үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцох;
- 4.5.2. Комиссын үйл ажиллагаа болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаар сургалтад жилд 2 (хоёр)-оос доошгүй удаа заавал хамрагдах;
- 4.5.3. Бүрэлдэхүүнд нь орсон хэргийн ажиллагаанд идэвхтэй, санаачлагатай, шуурхай ажиллах;
- 4.5.4. ажиллагааны нууцыг задруулахгүй байх;
- 4.5.5. хариуцлагатай, өндөр ёс зүйтэй байх;
- 4.5.6. хараат бус, бие даасан, бусдын аливаа нөлөөллөөс ангид байх;
- 4.5.7. хараат бус, бие даасан байдалд нөлөөлөхийг оролдсон, нөлөөлсөн аливаа үйлдлийг Комиссын даргад нэн даруй мэдээлэх;
- 4.5.8. бусад үүрэг;
- 4.6. Комиссын гишүүдийг дараах тохиолдолд хугацаанаас нь өмнө чөлөөлж, нэрсийн жагсаалтаас хасна. Үүнд:
- 4.6.1. өөрөө хүсэлт гаргасан;
- 4.6.2. нар барсан;
- 4.6.3. эрх зүйн чадамжгүй болсон;
- 4.6.4. ёс зүйн дүрмийг зөрчсөн;
- 4.6.5. авлига, хээл хахууль авсан нь нотлогдсон;
- 4.6.6. арбитрын болон Комиссын нэр хүндэд харшилсан үйлдэл эс үйдэл гаргасан;
- 4.6.7. ажиллахад харшлах өөр ажил, албан тушаалд томилогдсон;
- 4.6.8. энэхүү дүрмийн 4.5.2-4.5.7-д заасан үүргээ биелүүлээгүй эсхүл зөрчсөн;
- 4.7. Комиссын хөгжилд онцгой хувь нэмэр оруулсан гишүүнд “Хүндэт гишүүн”-ий өргөмжлөл, шагнал олгож болно. Хүндэт гишүүний өргөмжлөлийн загвар, журмыг Удирдах зөвлөл батална. Хүндэт гишүүний өргөмжлөлийг гишүүний дурсамж, дурсгалд зориулан нөхөн олгож болно.

- 5.1. Комиссын захиргааны үйл ажиллагааг Спортын арбитрын Ажлын алба нь хариуцаж, дэмжлэг үзүүлнэ. Ажлын албыг Ажлын албаны дарга удирдана.
- 5.2. Ажлын албаны дарга түүний эрх, үүрэг
  - 5.2.1. Комиссын хэргийн дугаар олгож бүртгэлийг хөтлөх;
  - 5.2.2. өргөдөл, нэхэмжлэл, гомдол, хүсэлтийг хүлээн авах, бүрдүүлбэрийг хянах;
  - 5.2.3. хэргийг нарийн бичгийн даргад хуваарилах;
  - 5.2.4. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг тогтмол хангаж, нарийн бичгийн дарга нарыг удирдах, үүрэг даалгавар өгөх;
  - 5.2.5. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой Комиссын дарга, Бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг даалгаврыг биелүүлэх болон хүсэлтийг шийдвэрлэх;
  - 5.2.6. хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процесстой холбоотой Бүрэлдэхүүнд санал, зөвлөмж өгөх;
  - 5.2.7. хууль болон дүрэмд заасан бусад эрх, үүргийг хэрэгжүүлэх;
- 5.3. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хуралдааны нарийн бичгийн дарга нь эрх зүйч мэргэжилтэй байх бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 5.3.1. хуваарилсан хэргийг хүлээн авч ажиллагааг эхлүүлэх, ажиллагааг шуурхай явуулах;
  - 5.3.2. хуралдааны бэлтгэл ажлыг хангах, зохион байгуулах;
  - 5.3.3. хуралдаанд нарийн бичгийн даргаар ажиллах;
  - 5.3.4. хуралдааны бичлэг хийх, тэмдэглэл хөтлөх, тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцах;
  - 5.3.5. Бүрэлдэхүүн болон талуудад хэргийн талаарх мэдээллээр хангах;
  - 5.3.6. Комиссын дарга болон Ажлын албаны даргад шуурхай мэдээлж, дэмжлэг тусламж авах
  - 5.3.7. Бүрэлдэхүүнээс өгсөн үүрэг, даалгаврыг шуурхай гүйцэтгэх
  - 5.3.8. ажиллагааны нууцыг чандлан хадгалах
  - 5.3.9. Бусад
- 5.4. Мэргэжилтэн нь эрх зүйч, орчуулагч, гадаад харилцааны мэргэжилтэй байж болох бөгөөд дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.
  - 5.4.1. үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан, маркетинг, хүний нөөц, эд хөрөнгийн ашиглалт, захиран зарцуулалт
  - 5.4.2. гадаад, дотоод хамтын ажиллагаа
  - 5.4.3. судалгаа, сургалт, шинжилгээ
  - 5.4.4. мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ
  - 5.4.5. бусад

## **ЗУРГАА. ХАРААТ БУС, БИЕ ДААСАН БАЙДАЛ**

- 6.1. Комисс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бие даан, хараат бусаар, бусдын аливаа нөлөөнд автахгүйгээр хөндлөнгийн байр сууриас явуулна.
- 6.2. Комисс нь допингийн эсрэг давж заалдах, хянан шийдвэрлэх, шийдвэр гаргах бүхий л үйл ажиллагаа нь Үндэсний допингийн эсрэг байгууллага болон аливаа гуравдагч этгээдээс ангид байна.
- 6.3. Комисс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа болон санхүүгийн хувьд хараат бус, бие даасан байдлаар ажиллах нөхцөлийг хангах талаар Холбоо болон Спортын арбитраас бүх талын дэмжлэг, тусалцааг авна.
- 6.4. Комиссын гишүүнээр томилогдож, нэрсийн жагсаалтад орсон гишүүн Спортын арбитрын нэрсийн жагсаалтад орох, тэдгээрийн явуулж буй хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохыг

хориглоно. Спортын арбитрчийг зөвхөн Комиссын даргын шийдвэрээр Комиссын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны Бүрэлдэхүүнд оролцуулж болно.

- 6.5. Комиссын дарга, гишүүд нь Монгол Улсын бусад байнгын арбитрын арбитрчийн нэрсийн жагсаалт буюу Бүрэлдэхүүнд харьяагдахгүй байх.
- 6.6. Комиссын гишүүд нь Эвлэрүүлэн зуучлалын болон Спортын арбитрын өмнө аливаа талын хуульчийн эсвэл зөвлөх, шинжээчийн үүрэг гүйцэтгэхгүй.
- 6.7. Комиссын гишүүд томилогдмогцоо өөрсдийн чиг үүргийг энэхүү дүрмийн заалтуудад нийцүүлэн бүрэн дүүрэн, бодитой, хараат бусаар, биечлэн хэрэгжлүүлэх үүрэг хүлээсэн албан ёсны мэдэгдэлд гарын үсэг зурна.
- 6.8. Бүрэлдэхүүнд орсон гишүүн нь тухайн маргааны талаар талууд болон төлөөлөгч, өмгөөлөгч нарт өмнө нь мэргэжлийн зөвлөгөө үзүүлж байгаагүй, тэдгээрийн төрөл садангийн болон ажил үүрэг, эд хөрөнгийн хувьд холбоогүй, ашиг сонирхлын зөрчилгүй байна.
- 6.9. Комиссын үйл ажиллагааны болон хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бие даасан, хараат бус байдалд нөлөөлөх гэсэн аливаа үйлдэл эс үйдлийг таслан зогсоох, холбогдох этгээдэд мэдээлэх, шаардлага хүргүүлэх зэргээр өөрсдийн эрхийг хамгаална.

### **ДОЛОО. КОМИССООС БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ**

- 7.1. Комисс нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хараат бус, бие даасан, үнэн зөв, шуурхай, тасралтгүй, шударга явуулах зорилгоор Дэлхийн допингийн эсрэг дүрэм, Допингийн эсрэг үндэсний дүрэмд заасны дагуу Дэлхийн допингийн эсрэг байгууллага, тивийн, бүсийн болон мэргэжлийн байгууллагатай бүх талаар хамтран ажиллана.
- 7.2. Комисс нь шинжээч болон зөвлөх томилох, нотлох баримтыг гаргуулах, лавлагаа, тайлбар, мэдээлэл гаргуулах зорилгоор гадаад болон дотоодын төрийн, төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, туслалцаа, дэмжлэгийг авах эрхтэй.
- 7.3. Комисс нь үйл ажиллагааны хувьд тасралтгүй, санхүүгийн хувьд бие даасан, хараат бус байдлыг хангах техник технологийн дэмжлэг, тусламж авах, мэргэжилтэн бэлтгэх, харилцан солилцох, төсөл хөтөлбөр хэрэгжүүлэх зорилгоор Дэлхийн допингийн эсрэг байгууллага, Олон улсын болон үндэсний байгууллагатай хамтран ажиллана.
- 7.4. Төрийн байгууллагаас Комиссын үйл ажиллагаанд, Комиссоос төрийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцохгүй байх зарчим баримтална.
- 7.5. Комисс нь бусад олон улсын болон төрийн бус байгууллага, нийгэмлэг, холбоод, танхим, арбитртай харилцахдаа харилцан хүндэтгэх, дэмжин туслах, хамтран ажиллах зарчим баримтална.
- 7.6. Комисс нь хэрэг хянан шийдвэрлэхээс бусад асуудлаар өөрийн үйл ажиллагааны хүрээнд хамрагдах асуудлаар төр, засгийн байгууллагатай зөвшилцөх, хамтран ажиллана.

### **НАЙМ. БУСАД**

- 8.1. Энэхүү дүрмийг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.